



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2016 оны 05 сарын 02 өдөр

Дугаар А/63

Улаанбаатар хот

Өмч, эд хөрөнгийн үзлэг, тооллогын явцад
хяналт тавьж ажиллах комисс томилох тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 72 дугаар зүйлийн 72.1 дэх заалт, нийслэлийн Засаг даргын "Нийслэл, дүүргийн өмчийн эд хөрөнгийн үзлэг, тооллогын ажлыг зохион байгуулах тухай" 2016 оны А/298 дугаар захирамж, нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам"-ын 2.4.1 дэх заалт, Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1.Захирагчийн ажлын албаны харьяа газруудын өмчийн эд хөрөнгийн үзлэг, тооллогын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах комиссын бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралтаар, ажлын удирдамжийг 2 дугаар хавсралтаар, шаардагдах зардлын тооцоог 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Байгууллагад өмчийн эд хөрөнгийн үзлэг, тооллогын ажлыг явуулах комиссыг 2016 оны 05 дугаар сарын 01-ний дотор байгуулж, ажлыг тогтоосон хугацаанд чанартай зохион байгуулж, дүн мэдээг тайлагнаж ажиллахыг харьяа байгууллагуудын удирдлагуудад үүрэг болгосугай.


3.Хяналтын комиссоос харьяа газруудад ажиллахад шаардагдах 276,816 /Хоёр зуун далан зургаан мянга найман зуун арван зургаан мянга/ төгрөгийг бараа үйлчилгээний зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Б.Цэрмаа/-д зөвшөөрсүгэй.

4.Харьяа газруудын өмчийн эд хөрөнгийн үзлэг, тооллогын дүнг нэгтгэн 2016 оны 05 дугаар сарын 27-ны дотор Хотын Ерөнхий менежерийн зөвлөлд танилцуулахыг Үйл ажиллагааны мониторингийн хэлтэс /Ц.Рэгзэдмаа/-т даалгасугай.

ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР БӨГӨӨД
ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА Б.БАДРАЛ



Хотын Ерөнхий менежерийн 2016 оны 05
дугаар сарын 02-ны өдрийн 163 дүгээр
тушаалын дүгээр хавсралт



ХЯНАЛТЫН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Комиссын дарга	Ц.Рэгзэдмаа	Үйл ажиллагааны мониторингийн хэлтсийн дарга
Гишүүд	Д.Булган	Захиргаа, санхүүгийн хэлтсийн Ахлах ня-бо
	Б.Эрдэнэбат	Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн мэргэжилтэн
	Б.Оюунсүрэн	Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Өмчийн хөдөлгөөн хувьчлалын хэлтсийн мэргэжилтэн /зөвшилцсөнөөр/
	С.Аригуун	Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн мэргэжилтэн
	З.Мөнгөнзул	Үйл ажиллагааны мониторингийн хэлтсийн мэргэжилтэн
	Б.Эрдэнэбат	Үйл ажиллагааны мониторингийн хэлтсийн мэргэжилтэн
	Л.Алтангэрэл	Инженерийн байгууламжийн хэлтсийн мэргэжилтэн
	Т.Оюунтөгс	Инженерийн байгууламжийн хэлтсийн мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга	Б.Гэрэл	Үйл ажиллагааны мониторингийн хэлтсийн мэргэжилтэн

Хотын Ерөнхий менежерийн 2016 оны
05 дүгээр сарын 02-ны өдрийн 1/03
дугаар тушаалын 2 дугаар хавсралт

**ХАРЬЯА ГАЗРУУДЫН ӨМЧИЙН ЭД ХӨРӨНГИЙН ҮЗЛЭГ, ТООЛЛОГЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ТАВЬЖ АЖИЛЛАХ
АЖЛЫН УДИРДАМЖ**

Нэг. Зорилго.

1.1.Захирагчийн ажлын албаны харьяа газруудын өмчийн эд хөрөнгийн үзлэг, тооллогын үйл ажиллагаа болон нийтийн эзэмшлийн байгууламж, бусад хөрөнгийг тооллогод бүрэн хамруулсан байдалд хяналт тавьж, дүнг нэгтгэн Хотын Ерөнхий менежерийн Зөвлөлд танилцуулах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг боловсруулан **нийслэлийн тооллогын комисст** хүргүүлэх.

Хоёр. Хамрах хүрээ, хугацаа.

2.1.Захирагчийн ажлын албаны харьяа 8 байгууллагыг хамруулан 2016 оны 05 дугаар сарын 02-ны өдрөөс **05 дугаар сарын 20-ны** хооронд хяналтын тооллогын ажлыг зохион байгуулна.

2.2.Хяналтын комисс үзлэг тооллогын ажлын мөрөөр нэгдсэн дүн шинжилгээ хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг Ерөнхий менежерийн зөвлөлийн хуралд **05 дугаар сарын 27-ны** дотор танилцуулж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг **нийслэлийн тооллогын комисст** хүргүүлнэ.

Гурав. Бүрэлдэхүүн.

Байгууллагын тооллогын комисс нь өөрийн өмчийн эд хөрөнгийн үзлэг, тооллогын ажлыг тогтоосон хугацаанд зохион байгуулж, Хотын Ерөнхий менежерийн тушаалаар байгуулагдсан "Харьяа газруудын өмчийн эд хөрөнгийн үзлэг, тооллогын явцад хяналт тавьж ажиллах комисс" /цаашид "Хяналтын комисс" гэх/ хяналтын үзлэг, тооллогыг явуулна.

Дөрөв. Хяналтын комиссын ажлын чиглэл.

4.1. Харьяа газрууд Өмчийн эд хөрөнгийн үзлэг, тооллогын ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71, 72, 73 дугаар зүйл болон Сангийн сайдын 2016 оны 126 тушаалаар батлагдсан Төрийн болон орон нутгын өмчийн тооллого явуулах журмын дагуу зохион байгуулж буйд хяналт тавих,

4.2. Харьяа газруудаас ирүүлсэн өмчийн эд хөрөнгийн үзлэг тооллогын дүн, ажлын тайлан мэдээг нягтлан шалгасны дагуу эд хөрөнгөд түүвэрчилсэн хэлбэрээр үзлэг, тооллого явуулах,

4.3.Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй хөрөнгөөс гадна орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар барьж байгуулсан барилга байгууламж, далан суваг, бусад нийтийн эзэмшлийн байгууламж, үндсэн хөрөнгийг тооллогод бүрэн хамруулсан байдалд хяналт тавих,

4.4.Харьяа байгууллагуудын үзлэг тооллогын мөрөөр илэрсэн алдаа дутагдал, түүнийг арилгасан байдалд хяналт тавьж, үндсэн хөрөнгийн дансны ангилалд зөв ангилан бүртгэх, шаардлагатай тохиолдолд шилжүүлэн бүртгэх, данснаас хасах зэрэг асуудлаар санал дүгнэлт гаргах,

Тав. Ажлын зохион байгуулалт.

5.1. Харьяа байгууллагуудаас 2015 оны жилийн эцсийн тооллогын дүнг 2016 оны 05 дугаар сарын 05-ны дотор /урьдчилсан байдлаар/ Хяналтын ажлын хэсэгт ирүүлсэн байна.

5.2.Хяналтын комиссоос байгууллагуудын 2015 оны хөрөнгийн тооллогын дүн мэдээтэй танилцаж, удирдамжийн 4-т заасан чиглэлийн дагуу өмч хөрөнгийн бүртгэлд хяналтын ажиллагаа, түүвэрчилсэн үзлэг, тооллогын ажлыг явуулах ба нөхцөл байдлыг нотлох бүхий л боломжтой арга хэлбэрийг сонгож хэрэглэн шаардлагатай тохиолдолд бодит байдлыг дүрс бичлэг, гэрэл зураг, цаасан болон цахим байдлаар баталгаажуулна.

5.3.Үзлэг, тооллогын явцад тооллогын бүртгэлд гарсан алдаа дутагдал, зөрчлийг арилгуулах асуудлаар хугацаатай үүрэг даалгавар өгч, холбогдох маягтыг бүрдүүлэх ажлыг гүйцэтгүүлж /Маягт ТӨ 9-12 болон бусад/, тайлан мэдээнд тусгуулна. /бүртгэлгүй, дутагдсан, нэр төрөл тоо хэмжээ, марк үзүүлэлт нь зөрүүтэй гэх мэт/. Тооллогын явцад залруулах боломжгүй /цаг хугацаа болон эрх зүйн хувьд/ асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэрээр тусгуулах асуудлаар тооллогын тайлан мэдээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналд тусгуулна.

5.4.Үзлэг тооллогын явцад өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалт, ашиглалтын үйл ажиллагаанд хяналт тавьж, холбогдох асуудлаар зөвлөмж чиглэл өгнө.

5.6.Байгууллагын удирдлага, албан тушаалтнууд хяналтын комиссоос үзлэг тооллого явуулахад шаардлагатай нөхцөл боломжоор хангаж, зохих дэмжлэг үзүүлж ажиллана. /Үзлэг тооллогод хамаарагдах машин механизмыг тооллого явуулах газар, цагт бэлэн байлгах, эд хөрөнгийн бүртгэл мэдээллийн талаарх холбогдох баримт материалыг бүрдүүлэх, бэлтгэх, холбогдох албан хаагчдыг тухайн цаг үед ажлын байранд байлгах гэх мэт/

Зургаа. Өмчийн эд хөрөнгийн үзлэг, тооллогын дүн.

6.1. Харьяа газрууд өмчийн эд хөрөнгийн үзлэг, тооллогын дүн, тайланг 2016 оны 05 дугаар сарын 20-нд **Хяналтын комисст ирүүлнэ**. Мөн 1 хувийг дүүргийнхээ Засаг даргын Тамгын газарт хүргүүлнэ./

6.2.Харьяа байгууллагуудын тооллогын комиссын үйл ажиллагаанд хийгдсэн хяналт, Хяналтын комиссын ажлын үр дүн, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг нэгтгэн Ерөнхий менежерийн зөвлөлийн хуралд 05 дугаар сарын 27-ны дотор танилцуулж, хурлаас гарсан шийдвэрийг **нийслэлийн тооллогын комисст** хүргүүлнэ.

ТАНИЛЦСАН:

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МОНИТОРИНГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.РЭГЗЭДМАА

БОЛОВСРУУЛСАН:

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МОНИТОРИНГИЙН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН


Б.ГЭРЭЛ

ХЯНАЛТЫН КОМИССЫН АЖЛЫН ЧИГЛЭЛ

Д/д	Байгууллага	Үзлэг тооллогын хяналтын чиглэл	Шалгуур үзүүлэлт
1.	Нийтийн үйлчилгээний Улаанбаатар ОНӨААТҮГ нэгтгэл	Автомашин, барилга байгууламж, далан суваг, буу, бусад	-Үндсэн хөрөнгөд бүрэн бүртгэлтэй эсэх, /өмнөх байгууллагын данс бүртгэлээс хасагдсан эсэх/ -Машины бичиг баримтын бүрдэл, баталгаажуулалт. /марк дугаар, моторын дугаар/
2.	"Улаанбаатар лифт" НӨҮГ	Агуулахын сэлбэг бараа материал, бусад	
3.	Замын Хөдөлгөөний Удирдлагын төв	Шилэн кабель, автомашин, бусад	Зураглалтай тулгах
4.	Ус суваг удирдах газар	Хамгаалалтын бүсийн газар /захирамж, гэрчилгээ бусад/, бусад	
5.	Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газрын	Ус дулаан дамжуулах төвийн барилга /ЦТП/, бусад	Барилгын байгууламжийн паспорт, засвар шинэчлэлт хийсэн бол капитажуулсан баримт, шинэ барилга ашиглалтад оруулсан бол барилгын паспортыг бүртгэлд тусгах шийдвэр /НИТХ-ын тогтоол/
6.	Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар	Халаалтын тогоо, бусад	
7.	Монгол наадам цогцолбор	Барилга, байгууламж, үндсэн хөрөнгө, бусад	
8.	Шуурхай удирдлага зохицуулалтын төв	Хяналтын камер, бусад	

ХЯНАЛТЫН КОМИССЫН АЖЛЫН ЧИГЛЭЛ

Д/д	Байгууллага	Үзлэг тооллогын хяналтын чиглэл	Шалгуур үзүүлэлт	Комиссын гишүүн	Хугацаа
9.	Нийтийн үйлчилгээний Улаанбаатар нэгтгэл ОНӨААТҮГ	Автомашин, барилга байгууламж, далан суваг, буу, бусад	-Үндсэн хөрөнгөд бүрэн бүртгэлтэй эсэх, /өмнөх байгууллагын данс бүртгэлээс хасагдсан эсэх/ -Машины бичиг баримтын бүрдэл, баталгаажуулалт. /марк дугаар, моторын дугаар/	Ц.Рэгзэдмаа, С.Аригуун, Ба.Эрдэнэбат, Б.Оюунсүрэн	V/11
10.	"Улаанбаатар лифт" НӨҮГ	Агуулахын сэлбэг бараа материал, бусад		Б.Мөнгөнзул, Б.Гэрэл Б.Гэрэлтуяа	V/05
11.	Замын Хөдөлгөөний Удирдлагын төв	Шилэн кабель, автомашин, бусад	Зураглалтай тулгах	Т.Оюунтөгс, С.Аригуун н.Энхбаяр	V/05
12.	Ус суваг удирдах газар	Хамгаалалтын бүсийн газар /захирамж, гэрчилгээ бусад/, бусад		Ц.Рэгзэдмаа Ба.Эрдэнэбат, Б.Оюунсүрэн, Л.Алтангэрэл	V/05
13.	Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газрын	Ус дулаан дамжуулах төвийн барилга /ЦТП/, бусад	Барилгын байгууламжийн паспорт, засвар шинэчлэлт хийсэн бол капитажуулсан баримт, шинэ барилга ашиглалтад оруулсан бол барилгын паспортыг бүртгэлд тусгах шийдвэр /НИТХ-ын тогтоол/	Ц.Рэгзэдмаа Ба.Эрдэнэбат, Б.Оюунсүрэн, Л.Алтангэрэл	V/06
14.	Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар	Халаалтын тогоо, бусад		Л.Алтангэрэл Ба.Эрдэнэбат Н.Болормаа	V/09
15.	Монгол наадам цогцолбор	Барилга, байгууламж, үндсэн хөрөнгө, бусад		Ц.Рэгзэдмаа Бя.Эрдэнэбат, Д.Булган, Б.Гэрэл Б.Адьяа	V/10
16.	Шуурхай удирдлага зохицуулалтын төв	Хяналтын камер, бусад		Т.Оюунтөгс Б.Гэрэл н.Энхбаяр	V/06





Хотын Ерөнхий менежерийн 05... оны
05... дугаар сарын 02-ны өдрийн 05...
дүгээр тушаалын 03... дүгээр
хавсралт

ҮЗЛЭГ ТООЛЛОГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ШААРДАГДАХ ШАТАХУУНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ

Д/д	Явах чиглэл	Ажлын чиглэл	Улсын дугаар	Машин марк	Явах км-ийн хэмжээ /км/	Норм /литр/	Нийт зар/дах бензин /литр/	Нийг литр бензиний үнэ	Нийт үнэ
1	Нийтийн үйлчилгээний Улаанбаатар нэгтгэл ОНӨААТҮГ,	200	31-25 УНД	Тоёото хариер	720	15	108	1580₮	170,640₮
2	Ус сувгийн удирдах газар,	240							
3	Хэсэгчилсэн инженерийн удирдах газар,	280							
4	Орон сууцны удирдах газар	200	49-39 УНР	Тоёото кровн	480	14	67,2	1580₮	106,176₮
5	Замын хөдөлгөөний удирдлагын төв	60							
6	Монгол наадам цогцолбор	140							
7	УБ лифт	50							
8	Шуурхай удирдлага зохицуулалтын төв	30							
	Нийт	1200	8- байгууллага бааз, агуулах, тусгай хамгаалалтын бүс		1200		175,2	276,816₮	

Жич: 15 өдөр 2 суудлын автомашины жишгээр тооцов.

ТӨСӨВ ГАРГАСАН:
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МОНИТОРИНГИЙН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН:  Б.ГЭРЭЛ

ХЯНАЖ ЗӨВШӨӨРСӨН:
АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ:  Б.ЦЭРМАА